

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрмаа	Дугаар	L301
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Чандмань-өндөр сум
Төрсөн газар	Чандмань -Өндөр сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Одоогийн сүм хийд	Дашгэмпэнлин хийд	Сүм хийдийн дугаар	ХӨЧӨ 047
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Чандмань-өндөр сумын Дашгэмпэнлин хийд

Мөнхбат: За өнөөдөр манай судалгааны баг Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төвд судалгааны ажлаа үргэлжлүүлж байна. Ингээд судалгааны баг Чандмань-Өндөр сумын төв дээр байх Дашгэмпэнлин хийдийн одоо гадаа ирж, энэ Дашгэмпэнлин хийдийн үйл ажиллагааг байгуулагдсан цагаас нь , байгуулагдахаас өмнө нь урьдчилсан нөхцлийг нь бүрлүүлж, хөөцөлдөж, байгуулж өнөөдрийг хүртэл үйл ажиллагааг нь эрхлэн хөтөлж яваа энэ нутгийн харъяат, эдүгээ Улаанбаатар хотын харъяалалтай иргэн одоо өндөр настан Цэрмаа гуайтай дараах ярилцлагыг хийж байна. Тэгэхээр таниас дараах асуултыг асууя. Таньд энэ Дашгэмпэнлин хийдийг үүсгэн байгуулах ямар учир шалтгаан байв, Дашгэмпэнлин хийд маань байгуулагдаад өнөөдөр үндсэндээ одоо бас багагүй хугацааг өнгөрүүлсэн байна. Тэгэхээр тэр хийдийг эргэн байгуулж байсан тэр цагаа одоо эргэн дурсахгүй юу?

Цэрмаа: За тэгэхээр одоо манай энэ Дашгэмпэнлин хийд бол 2004 онд, дөрвөн оны долоон сарын хоёронд сэргээн босгох ажиллагаа явагдаж үйл ажиллагаа явуулсан. Энэ хугацаанд одоо гурван лам Улаанбаатарт

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

аваачиж сургасан. Асрал төв буюу, Асрал төвийн багш Лхаваанжалцан гэдэг багш дээр дөрвөн хүний зардал болгож тэнд бүх юмыг нь дааж , юу яалгасан.Орон байраар хангаж, хоол ундыг нь хангаж тэнд сургасан .Тэрний үндсэн дээр одоо тэр гурван лам маань буцаж ирээд энэ хийддээ одоо ажиллаж байгаа.Аа гэхдээ манай хийдийн ажиллагаа бол одоо голдуу дүйчэн өдрүүдээр явдаг.Аа бусад юутай өдрүүдэд бас ажиллана.Аа энэ гурав болохоор бас шинэ суусан боолхоороо өдөр болгон ажиллаж, өдөр болгон хүрээнийхээ амьдралд оролцож чаддаггүй юм аа.Ийм учраас одоо ерөөсөө бол бид нарын хамгийн гол зорилт хүсэлт бол энэ хийдийг байгуулах санаачилгыг гаргасан одоо энэ нутгийн олон сүсэгтэн олонгууд, энэ захиргааны засаг захиргаанаас биднийг дэмжиж энд одоо дуган хийд барьж, 2003 оноос энийг хөөцөлдөж байж яасан , олон сүсэгтэн олны хандиваар.Энэ сүсэгтэн олны хандиваар байгуулагдсан энэ хийдэд маань одоо анх эхлээд сүсэгтний холбоо гэж байгуулагдсан.Тэр маань нэлээн доорвитой ажиллаж байсан.Сүүлийн үед нөгөө холбоо молбоо нь ч тараад ингээд жаахан, одоогийн байдлаар жаахан тархай, бутархай байна аа. Ингээд бас хоёр тогооч ажиллаж байсан улсуудаас нь энэ хоёр тогооч, тэгээд нэг гурван ламтай би ингээд нэг дөрөв таван улсууд ингэж ажиллаж байна аа.

Мөнхбат: За дараа нь таниас асуух зүйл маань гэвэл энэ Дашгэмпэнлин хийд маань өнөөдөр ямар шүтээн сахиустай байна, за одоо та сая хэллээ, сар бүрийн дүйчэн онцгой өдөр хурал хурдаг, ингэж сүсэгтэн олондоо үйлчилдэг гэж. Ямар ямар номыг танай лам нар голлон хурж байна?

Цэрмаа: За манай лам нар бол энэ дүйчэн өдрөөр хурдаг хурлын дэг жаягийн дагуу жишээлбэл, одоо шинийн найманд Дарь эхийн мандал шива, арван таванд Сандунй жүд, Манал, хорин таванд болохлээр зэрэг Ламын чидав, арванд, шинийн арванд бас Ламын чидав уншдаг, иймэрхүү л юутай.

Мөнхбат: Шүтээн сахиус?

Цэрмаа: Шүтээнүүд маань, гол шүтээн маань болохлээр зэрэг яахав Гомбо сахиус. Аа манай энэ хийдийн маань бол...Гомбо шүтээнтэй манай хийд.Энэ Гомбо сахиусаа одоо сар бүрийн арван таванд тахиж байдаг юм аа.Аа үүнээс гадна энэ гадуур овоо, овоонуудын одоо тахилгын ажилд манай лам нар оролцож.Тэнд очиж олон түмэндээ буян хийж явдаг.Аа тэрнээс гадна чинь, манай энэ хийд чинь Гандан чойжоо гэх юм уу, Цагаан Ногоон дарь эх тэгээд зарим нэгэн бусад тарниудыг одоо суралцаж байдаг.Хүүхдүүд оролцож бас хамтран уншдаг юм аа.Шавилан суух санаатай нэлээн хэдэн улсууд байдаг.Тэр бүгд маань одоо өнөөдрийн байдлаар л ирээгүй байна.Энэ одоо олон ламтай, юутай толгой ламтай болвол эд нар маань явж наашаа сууж ажиллах байх аа гэж бодож байна .

Мөнхбат: Тэгэхээр таны түрүүчийн бидэнд өгсөн ярилцлаганаас анхаарч байхад Аригийн доод хүрээний ном судар, нутгийн айлууд, ахмадууд одоо эрдэм номтой өвгөчүүлээр дамжин манай одоо шинэ байгуулагдсан энэ Дашкэмпэнлин хийдэд өв залгамжлагдаж ирсэн гэж ярьсан.Тэгэхээр одоо энэ Аригийн доод хүрээнээс дамжиж ирсэн энэ ном судар яг хэдэн баринтаг ямар номнууд байна, танайх ер нь одоо ингээд шашны ном судрын хэр их нөөц баялагтай хийд вэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэрмаа: За манай хийд бол ерөөсөө ном судар бурхны зарим хэрэгслүүд болохлээр зэрэг бүрэн бий , манайд.Аа ном судрын хувьд бол дөрвөн зуу гаруй баринтагтай, шоголтой холилдсон ийм номнууд байгаа.

Мөнхбат: Бүгд одоо Аригийн хүрээнээс өвлөж залгамжлагдаж ирсэн?

Цэрмаа: Аа тэр Аригийн хүрээнээс ирсэн бөгөөд ирээгүй бас уул хаднаас олдсон, айл амьтнаас одоо ирсэн...

Мөнхбат: Хадгалагдаж байсан?

Цэрмаа: Хадгалагдаж байсан.Хээр одооноос олдсон ийм номнууд одоо цугларч ирээд байна.Одоогийн байдлаар бол яахав энэнийг би одоо тооцоод гаргасан л даа.

Мөнхбат: Тэгэхээр үнэхээр юу л даа, шинэ тутам байгуулагдаад удаагүй байгаа бурхан номын газруудад ийм эртний ийм судар ном олноороо залгамжлагдаж ирнэ гэдэг бол тийм элбэг байдаг тохиолдол биш. Тэгэхээр нэгэнт өвөг дээдсээсээ нутаг олныхоо, нутгийн хүмүүсийн гараар дамжин ингэж ирсэн энэ их одоо ном судар, оюуны маш их энэ нөөцийг үр дүнтэй ашиглаж, уншиж одоо сүсэгтэн олондоо үйлчлүүлэх нь мэдээж шинэ тутам байгуулагдсан энэ Дашгэмпэнлин хийдийн мэдээж хойшлуулшгүй зорилго зорилтын нэг юм аа гэж ингэж бидний хувьд үзэж байна.Тэгэхээр таниас сүүлчийн асуултаа асуухад ер нь Дашгэмпэнлин хийдээ цаашид байнгын үйл ажиллагаатай болгоход одоо ямар ямар одоо эхний зорилтуудыг дэвшүүлээд л одоо бодлого болгон ажиллаж байна даа?

Цэрмаа: За бид нар бол ер нь одоо энэ Дашгэмпэнлин хийдийг цааш нь ажиллуулахын төлөө л ёстой өдөр шөнөгүй чармайн ажиллаж байна.Гэхдээ одоо нутгийн олон ард түмэн маань биднийг их дэмжиж байгаа.Бид одоо цаашид ажиллахад одоо лам нарын хувьд хамгийн нэгдүгээрт асуудалтай, зовлонтой юм байдаг юм аа. Аа бид нар одоо тэгээд л гурван ламтай, тэр лам маань одоо авгай хүүхэд энээ тэрээ болоод юундаа бүрэн оролцож өгөхгүй, хуралдаа ч бүрэн оролцож өгөхгүй нэг ийм тал гардаг. Энэнд одоо нэг толгой лам , энэнд одоо нэлээн сайн анхаарал тавьж өгөөсэй гэж одоо шашныхаа байгууллагаас хүсэж байна.Аа цаашдаа миний зорилго бол энэ манай суманд дээр болоод шашны сургуулийг бүр хүүхдээс болоод жижиг хүүхдээс авахуулаад үндэсний боловсон хүчинтэй болгох талаас нь одоо хүсэлт тавьж байна даа.Ингэхгүй л бол одоо энэ манай Дашгэмпэнлин хийд шиг л явж өгөхгүй байсаар байгаад л гурав, дөрвөн жил болчихож байна ш дээ, одоо.Энэндээ л одоо бүх юм, тэр аж ахуй бусад юмны талаар яахав бас боломжтой.Бас тэр бусад талаар , олон түмэн энд ажиллаж байгаа улсууд бол ер нь бүгдээрээ ажиллаж байхад бол буруу юу гэх юм байхгүй, дутаад байх юм байхгүй.Одоо нутаг орон маань ч их сайхан газар, энэ чинь.Аа ер нь хамгийн гол юм нь ерөөсөө лам нар л их дутагдаж байна.Одоогийн байдлаар бол би одоо Хатгал хотод сүм байгуулаад ажиллаж байгаа Амаржаргал гэдэг ламтай одоо хамтран ажиллахаар тохиролцоо хийсэн.Тэгээд Амаржаргал лам маань одоо өнөөдрөөс ирэх байх. Манай хоёр сүм хамтарч, тэр Амаржаргал манай нутгийн хүн. Энэ нутагтаа тэгээд энэ манай хийдийг зохион байгуулж байгаа, энд ажиллаж байгаа энэ лам нар энэ хүүхдүүдэд нь зааж сургаад, цаашдаа одоо том том л багш лам нарыг залж ирэхэд одоо тэр хүлээж авах ийм л юу яана. Аа мөн түүнчлэн тэгж байгаад өөрийнхөө нөгөө Хатгал хотод байгаа тэр хийд дээрээ одоо бас манай лам нарыг аваачиж, тэнд

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бас суралцаж хурал номонд оролцуулъя л гэсэн ийм үтгатай юм байгаа юм. Аа миний тавьж байгаа хүсэлт бол Их Хөлгөний төвөөс ч одоо бид нарыг харж үзэж, олон төрлийн ном судар бас тэр юу л байна, сонингоос өгсүүсээд л бүх юмыг гаргаж энэ нутгийн оло түмэнд үйлчилж ажилаач ээ л гэж ингэж хэлдэг. Би тэрийг сайн хүргэж ажиллаж чадахгүй байгаа бол миний л буруу байхгүй юу. Тэгээд одоо энэ бүхнийг л харж үзэж одоо ерөөсөө шашны сургууль байгуулахад л дэмжиж одоо энэ тал дээр нь л ажиллахгүй бол манай эндээс бол одоо хүн. Мөрөн ч одоо сурчих, одоо эдийн засгийн тал дээр бол юутай л даа, хүүхдүүд бас. Гэр орноосоо холдоод явчихдаг, олон хүүхэдтэй газар болохлээр. Одоо жишээ нь нэг хүүхэд явбал, нэг шашны сургуульд нэг хүүхэд өгвөл тэрэнд одоо заавал нэг юмуу, хоёр хүүхэд нь ерөнхий өөр сургуульд сурч байдаг. Тийм болохоор бас амьдралын хувьд хүрэлцээ муутай юм уу, Улаанбаатар хотоос одоо долоон зуугаад км газар байдаг. Мөрөнгөөсөө зуун дөчөөд км газарт байдаг юм ш дээ, манайх чинь. Ийм болохоор одоо нэлээн хот бөглүү газар байгаа. Ойролцоо хэдэн сумын ингээд лам нарыг нийлүүлж аваад ингээд энэ хавьд нэг сургууль байгуулж өгөөсэй л гэж одоо ингэж л хүсэж байна даа.

Мөнхбат: За баярлалаа. Тэгэхээр нэг бас нэг ганц асуулт үлдсэн байна, энэ Дашгэмпэнлин хийдийн үйл ажиллагааны зардал, санхүүжилтийг одоо хэрхэн яаж шийдэж байна аа, энэ талаар товчхон та ярьж өгөхгүй юу?

Цэрмаа: Манай энэ Дашгэмпэнлин хийдэд ер нь тийм тохижилт соёлжилт яах зардал бол улсаас, ерөөсөө энэ тэндээс зардал байхгүй ээ. Санхүүгийн мөнгө төгрөг байхгүй. Манай хэдэн улсууд өөрсдөө л энэ хүрээгээ тойрч лам нартаа үйлчилж, хоол үндны асуудлыг бид нар лам нарынхаа олсон юунаас ч юм уу, өөрсдөө бас талх малх бариад манай хэдэн тогооч нар маань зарж барьж ингэж нэг бор хоногоо өнгөрөөж байдаг юм аа. Тэгээд лам нар маань одоо цалин хэрэглэл байхгүй болохоороо сууж барьж чадахгүй байна аа. Суугаад байвал бас хүн амьтан ирээд мөнгө төгрөг яах байх аа. Бид нар одоо яахав гандан дээр олсон мөнгөнийхөө дөчин хувийг нь хурлынхаа юманд зориулна аа л гэсэн. Тэгээд одоо яахав энэ хурлаа авснаас хойш жаал жуугаахаан эд ахуйн тал дээр л яасан болохоос биш. Ер нь тэгээд бас нэг сайн тохижуулж чадахгүй байна аа. Бүрэн бүрэлдэхүүнээр ерөөсөө дун цангаас өгсүүлээд л бүх юм л манай дээр өвлөж ирсэн. Үнэхээр их ном судартай, манайх. Айлуудаас одоо ч гэсэн ном судраа авчирч өгж байгаа улсууд маш их байна. Энийг л тэгээд зохицуулаад л байж байвал, лам л хэрэгтэй байна даа. Санхүүгийн талаар бол цалин авч байгаа хүн байхгүй ээ, бид нарт. Анхны үед бол байгуулагдаад анхан хандиваар орж ирсэн мөнгө төгрөгөөр бол улсуудаа цалинжуулж л байсан юм гэнэ лээ. Намайг болвол яахав, цалинжуулж барьж энэ тэрээгүй ээ. Зүгээр лам нарынхаа хоолноос идэж байгаарай л гэсэн. Тэрнээс цай майг нь л уудаг байсан. Тэрнээс хойш бол ерөөсөө юм байхгүй л байгаа. Би бол энд одоо гурван жил ажиллаж байна аа.

Мөнхбат: За баярлалаа.